Бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах журмын зургаадугаар хавсралт

## ШУУД ХУДАЛДАН АВАЛТЫН ЗАХИАЛГЫН ХУУДАС

Огноо: 2024.03.04 Дугаар: 136-01-02-7.29.2.4 165

Нэгж: Салбарын *Хөдөлмөр аюулгүй байдал, байгаль орчны газар Байгаль орчин, усны бодлогын хэлтэс*

| № | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Багцын нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Зориулалт | Техникийн тодорхойлолт | Үлдэгдэл /тоо ширхэг/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Усны тоолуурын баталгаажуулалт, Тоосонцрын агууламж дахь хүнд металлын хэмжилт, Цацрагийн хяналт, шинжилгээ, Хаягжуулалт | Усны тоолуурын баталгаажуулалт | Багц | 1 | Уурхайн ашиглалтын худгуудын тоолуурын баталгаажуулалт хийх | Хавсралт №1 | |
| 2 | | Тоосонцрын агууламж дахь хүнд металлын хэмжилт | Багц | 2 | Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх агаарын чанарын сөрөг нөлөөллийн хянах | Хавсралт №2 | |
| 3 | | Цацрагийн хяналт, шинжилгээ | Багц | 3 | Уурхайн хүрээлэн буй орчны цацрагийн хяналт, хэмжилтийг хийлгэж хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд учрах аюулыг тодорхойлох | Хавсралт №3 | |
| 4 | | Хаягжуулалт | Багц | 4 | Мод үржүүлгийн талбайг тохижуулах, талбайд тариалсан ургамлуудыг хаягжуулах ажилд ашиглагдана | Хавсралт №4 | |

Хавсралт: 4 хуудастай

**Хавсралт №1**

## ЦЭВЭР УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖИЛТ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

**Зорилго:**

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын хэрэгжилтийг хангах үүднээс уурхайн ашиглалтын худгуудын тоолуурыг 2 жил тутамд хугацаа дууссан болон эвдэрсэн, гацсан тохиолдолд хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэдэг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар шалгуулж, тохируулга хийх хэрэгцээ шаардлага үүсдэг.

**Үндэслэл:**

"Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 6.8 дах заалтад заасан ус ашиглагчийн үүргээ биелүүлэх, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа, Цогтцэций сумын ЗДТГ-аас зохион байгуулсан хяналт шалгалтаар зөрчилгүй байх, сар бүрийн ус ашиглалтын актыг үнэн зөв тайлагнах, ус ашигласны төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад худгийн тоолуурыг баталгаажуулах шаардлага үүсдэг.

**Гүйцэтгэгч байгууллагад тавигдах ерөнхий шаардлага:**

- Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 4-ний өдрийнА/136 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журам"-ын шаардлагыг хангасан байх
- Хүйтэн усны тоолуур шалгах арга хэрэгсэл MNS 2662:2002 болон ундны хүйтэн ус ба халуун усны тоолуур хэмжил зүйн болон техникийн шаардлага MNS OIML R 49-1:2012 стандартуудын шаардлагад нийцсэн байх
- Усны тоолуурыг түүний заалтыг харах боломжтой, үзлэг, үйлчилгээ хийхэд тохиромжтой, гэрэлтүүлэгтэй, агаарын температур +5°С-аас багагүй дулаан өрөөтэй байх
- Усны тоолуурын засвар тохиргоо хийх үйл ажиллагааг шалгалтын суурин эталон тоног төхөөрөмжийн тусламжтайгаар гүйцэтгэх

**Хийгдэх ажил:**

Тоолуурын баталгаажилтын хугацаа дууссан болон ашиглалтын үед эвдэрсэн, гэмтсэн, гацсан нийт 9 ширхэг тоолуурыг шалгаж, баталгаажуулах, цаашид ашиглах боломжтой эсвэл шинээр солих гэх мэт мэргэжлийн дүгнэлт гаргаж өгөх шаардлагатай.

| № | Худгийн дугаар | Тоолуурын диаметр, мм | Гэрчилгээний дугаар | Баталгаажилт дуусах огноо |
|---|---|---|---|---|
| 1 | Худаг 19 | 50 | 024574 | 2024.06.23 |
| 2 | Худаг 20 | 50 | 024853 | 2024.08.08 |
| 3 | Худаг 22 | 50 | 071767 | 2025.03.23 |
| 4 | Худаг 23 | 32 | 075234 | 2025.04.10 |

**Хавсралт №2**

## ТООСОНЦОРЫН АГУУЛАМЖ ДАХЬ ХҮНД МЕТАЛЛЫН ХЭМЖИЛТ АЖЛЫН ДААЛГАВАР

**Зорилго:**

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар дахь тоосонцорын хэмжээ нь MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлагын стандартаас 2-3 дахин давсан үзүүлэлттэй байгаа ба тус агаарт байгаа тоосонцор нь химийн маш олон төрлийн хортой бодисыг агуулж байдаг. Уурхайн хэмжээнд агаарын чанарын хяналтын цэг болон Цогтцэций сумын хяналтын цэгт тоосонцорт агуулагдаж буй хүнд металлыг шинжлүүлж хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд учруулж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох, хариу арга хэмжээ авч ажиллах зорилготой.

**Үндэслэл:**

Цанхийн баруун, зүүн уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд агаарын чанарын хүнд металлын агууламжийг шинжлүүлэх тухай тусгагдсан. */ЦБУ БОННҮ тайлан Ху.439/*

**Гүйцэтгэгч байгууллагад тавигдах ерөнхий шаардлага:**

- Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн эрх бүхий сертификаттай байх
- Монгол улсын стандартын дагуу шинжилгээг хийх
- Мэргэжлийн лаборанттай байх

**Хийгдэх ажил:**

- Жилд 1 удаа "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Салбар уурхайд ирж сорьц цуглуулан өөрсдийн итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийнэ.
- Сорьц цуглуулахад шаардлагатай нэмэлт хэрэгслүүдийг бэлтгэн авч ирнэ.
- Шинжилгээний дүнг 14-21 хоногт багтаан захиалагчид эх хувиар болон цахим хаягаар ирүүлнэ.
- Уурхайд ирж ажил гүйцэтгэх ажилтны замын зардал, байр хоолны зардлыг захиалгын үнийн дүнд оруулж тооцно.

**Хэмжих үзүүлэлтүүд:**

| Үзүүлэлт | Шинжилгээний аргын стандарт |
|---|---|
| 13 элемент/Al, As, Be, Cd, Cr, Cu, Fe, Pb, Mo, V, Mn, Ni, Zn/ | ISO 15202:2014 |

**Хэмжилт хийх цэгүүдийн байршил болон давтамж:**

| Байршил | Цэгүүдийн тоо | Шинжилгээ хийлгэх давтамж |
|---|---|---|
| Хяналтын цэг | 4 | Жилд 1 удаа |
| Цогтцэций сум | 1 | |
| Нийт цэгийн тоо | 5 | |

**Хавсралт №3**

## ЦАЦРАГИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

**Зорилго:**

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн уурхайн хүрээлэн буй орчны цацрагийн хяналт, хэмжилтийг хийлгэж хүрээлэн буй орчин болон хүний эрүүл мэндэд учрах аюулыг тодорхойлох.

**Үндэслэл:**

Цанхийн баруун, зүүн уурхайн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд цацрагийн хяналт хийх тухай тусгагдсан. */ЦБУ БОННҮ тайлан Ху.440/*

**Гүйцэтгэгч байгууллагад тавигдах ерөнхий шаардлага:**

- Мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторийн эрх бүхий сертификаттай байх
- Хэмжилт хийхэд шаардлагатай цацрагийн хэмжилтийн зөөврийн багаж тоног төхөөрөмжтэй байх

**Хийгдэх ажил:**

- Жилд 1 удаа "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Салбар уурхайд ирж хэмжилт хийнэ.
- Хэмжилтийн дүнг 10-14 хоногт багтаан захиалагчид эх хувиар болон цахим хаягаар ирүүлнэ.
- Уурхайд ирж ажил гүйцэтгэх ажилтны замын зардал, байр хоолны зардлыг захиалгын үнийн дүнд оруулж тооцно.
- Хэмжилтийн төхөөрөмжид баталгаажуулалт хийгдсэн байх.

**Хэмжих үзүүлэлтүүд:**

- Орчны гамма цацрагийн тунгийн хэмжээ
- Орчны агаар дахь радоны концентраци

**Хэмжилт хийх цэгүүдийн байршил болон давтамж:**

| Байршил | Цэгүүдийн тоо | Шинжилгээ хийлгэх давтамж |
|---|---|---|
| Хяналтын цэг | 4 | Жилд 1 удаа |
| Цогтцэций сум | 1 | |
| Нийт цэгийн тоо | 5 | |

**Хавсралт №4**

## ХАЯГЖУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Зорилго:**

Мод үржүүлгийн талбайг тохижуулах, талбайд тариалсан ургамлуудыг хаягжуулах ажилд ашиглагдана.

**Тавигдах шаардлага:**

- ✓ Хаягны хэвлэлтийн эх бэлтгэлийг "ЭТТ" ХК-ийн байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран гаргана. (Голт бор, сухай, шар хуайс, агч, монос, бүйлс, гүйлс, хайлаас, тоорой, жигд, чацаргана, бургас, заг, харгана) ургамлын Монгол, Латин нэршилтэй, 2 талдаа хэвлэлттэй байх шаардлагатай.
- ✓ Захиалагчид нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нь ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан үзүүлэлтээс зөрөөгүй байна.

| № | Бүтээгдэхүүний нэр | Тоо хэмжээ | Техникийн тодорхойлолт | Зураг |
|---|---|---|---|---|
| 1 | Самбар | 14ш | 30x20см хэмжээтэй. 150см өндөр шонтой. Шон 50мм-ийн трубагаар хийгдсэн байна. Металл гадаргуутай. Самбарын шон болон, хүрээг сайн чанарын ногоон өнгийн төмрийн будагаар будсан байх шаардлагатай. |  |
| 2 | Хэвлэл | 14ш | 30x20см хэмжээтэй хэвлэл байна. | |